



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

БОГДХАН УУЛЫН ДАРХАН ЦААЗАТ ГАЗРЫН ХАМГААЛАЛТЫН
ЗАХИРГААНЫ 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

АУДИТЫН КОД: АХГ-2022/12/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх
аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Г.Гүнжидмаа
Утас: 261885 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn
Аудитор: С.Алтанхуяг
Утас: 262618 Цахим хаяг: altankhuyags@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Нью Эстимэйтор Аудит ХХК
Захирал: Т.Бүжидмаа
Утас: 95157097, 98000688 Цахим хаяг: jukhertar@yahoo.com

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
3. Аудитын тайлан.....	13
3.1 Ерөнхий зүйл.....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Материаллаг байдал	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	16
3.8 Аудитын гол асуудал	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
4. Аудитын илрүүлэлт	18
4.1 Залруулсан алдаа	18
4.2 Албан шаардлага	18
4.3 Зөвлөмж.....	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БОАЖЯ	Байгаль орчин аялал жуулчлалын яам



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

БОГДХАН УУЛЫН ДАРХАН ЦААЗАТ
ГАЗРЫН ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГААНЫ
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Н.ПҮРЭВЖАВ ТАНАА

2022.02.25 № 07/415
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний байгууллагаас цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 22,602.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа эсвэл нийтээрээ материаллаг боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйл 25.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл 20.2.4 дахь заалтууд, Тохиолдсон байх, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	281,352,879.17	109,673,184.33
33	АВЛАГА	160,669,900.00	650,117.86
33300	Татаас, санхүүжилтийн авлага	160,669,900.00	00.00
335	Бусад авлага	00.00	650,117.86
3351	Байгууллагаас авах авлага	00.00	650,117.86
35	БАРАА МАТЕРИАЛ	120,682,979.17	109,023,066.47
354	Хангамжийн материал	54,932,979.17	41,823,066.47
35410	Бичиг хэргийн материал	1,775,100.00	1,566,703.00
35420	Аж ахуйн материал	8,367,718.20	8,106,635.20
35440	Түлш, шатах тослох материал	9,239,500.00	6,180,000.00
35470	Бусад хангамжийн материал	35,550,660.97	25,969,728.27
35500	Биологийн хөрөнгө	65,000,000.00	67,200,000.00
35600	Мал амьтад	750,000.00	00.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	804,168,064.78	950,717,505.44
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	804,168,064.78	950,717,505.44
392	Биет хөрөнгө	544,222,064.78	690,771,505.44
39201	Барилга, байгууламж, орон сууц	217,772,993.00	217,772,993.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(21,908,950.02)	(45,570,349.86)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	157,225,573.78	415,715,297.70
39204	Хуримтлагдсан элэгдэл	(60,976,552.22)	(95,782,900.73)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	101,829,786.66	101,829,786.66
39206	Хуримтлагдсан элэгдэл	(40,435,558.14)	(60,801,515.58)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	38,581,693.54	45,030,793.54
39208	Хуримтлагдсан элэгдэл	(11,867,162.83)	(20,795,754.87)
39214	Бусад үндсэн хөрөнгө	206,785,942.80	229,649,578.80
39215	Хуримтлагдсан элэгдэл	(42,785,701.79)	(96,276,423.22)
393	Биет бус хөрөнгө	259,946,000.00	259,946,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	259,946,000.00	259,946,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,085,520,943.95	1,060,390,689.77
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,085,520,943.95	1,060,390,689.77
51	Засгийн газрын хувь оролцоо	1,085,520,943.95	1,060,390,689.77
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	721,519,092.36	721,519,092.36
51101	Өмч: - төрийн	721,519,092.36	721,519,092.36
512	Хуримтлагдсан үр дүн	338,477,636.57	313,347,382.39
51210	Өмнөх үеийн үр дүн	338,477,636.57	338,477,636.57
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	(25,130,254.18)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	25,524,215.02	25,524,215.02
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,085,520,943.95	1,060,390,689.77

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,136,443,171.38	889,760,919.92
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	125,427,563.38	305,008,959.92
120	Нийтлэг татварын бус орлого	125,427,563.38	305,008,959.92
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	120,227,563.38	305,008,959.92
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20,980,260.00	16,206,500.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	99,247,303.38	288,802,459.92
120009	Бусад орлого	5,200,000.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,011,015,608.00	584,751,960.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	573,050,500.00	580,623,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	573,050,500.00	580,623,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	437,965,108.00	4,128,960.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,382,000.00	4,128,960.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	407,054,108.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	16,529,000.00	00.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	813,999,216.24	917,941,174.10
21	УРСГАЛ ЗАРДАЛ	813,999,216.24	917,941,174.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	763,647,966.17	711,978,632.01
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	383,560,536.79	398,302,688.32
210101	Үндсэн цалин	264,831,467.98	240,342,829.57
210102	Нэмэгдэл	83,355,100.00	102,869,858.75
210103	Унаа хоолны хөнгөлөлт	35,373,968.81	55,090,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	45,668,794.33	52,265,481.00
210201	Тэтгэврийн даатгал	32,579,591.24	38,303,723.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,051,923.83	3,559,749.02
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,136,649.71	3,263,906.41
210204	Ажилгүйдлийн даатгал	627,329.92	648,918.52
210205	Эрүүл мэндийн даатгал	6,273,299.63	6,489,184.06
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,041,233.83	4,680,498.94
210301	Гэрэл, цахилгаан	1,836,027.50	2,858,900.00
210302	Түлш, халаалт	2,297,706.33	1,425,598.94
210303	Цэвэр, бохир ус	907,500.00	396,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	60,324,429.00	30,302,362.93
210401	Бичиг хэрэг	6,441,468.00	1,656,397.00
210402	Тээвэр, шатахуун	21,556,700.00	25,328,460.00

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,632,100.00	746,422.93
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	26,494,161.00	851,083.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	00.00	120,000.00
210408	Бараа материал асгалсны зардал	3,200,000.00	1,600,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,105,000.00	9,100,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	9,100,000.00
210604	Урсгал засвар	4,105,000.00	00.00
2107	Томилолт, зочны зардал	3,520,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	3,520,000.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	190,034,744.98	74,789,648.86
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	186,824,366.98	67,324,244.86
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,485,000.00	6,115,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	433,328.00	400,950.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,107,250.00	949,454.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	184,800.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	71,393,227.24	142,537,951.96
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,218,048.58	1,284,932.70
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	65,175,178.66	141,253,019.26
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	50,351,250.07	205,962,542.09
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,471,420.00	18,735,600.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	16,471,420.00	18,735,600.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	33,879,830.07	187,226,942.09
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	33,879,830.07	187,226,942.09
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	322,443,955.14	(28,180,254.18)
4	Бараа материал худалдсаны олз /биологийн хөрөнгө нас дэвшүүлсэн/	00.00	3,050,000.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	322,443,955.14	(25,130,254.18)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	721,519,092.36	25,524,215.02	16,033,681.43	763,076,988.81
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	721,519,092.36	25,524,215.02	16,033,681.43	763,076,988.81
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	322,443,955.14	322,443,955.14
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	721,519,092.36	25,524,215.02	338,477,636.57	1,085,520,943.95
2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	721,519,092.36	25,524,215.02	338,477,636.57	1,085,520,943.95
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	721,519,092.36	25,524,215.02	338,477,636.57	1,085,520,943.95
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	(25,130,254.18)	(25,130,254.18)
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	721,519,092.36	25,524,215.02	313,347,382.39	1,060,390,689.77

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,031,995,868.00	761,628,360.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	20,980,260.00	16,206,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	20,980,260.00	16,206,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	20,980,260.00	16,206,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20,980,260.00	16,206,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,011,015,608.00	745,421,860.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	573,050,500.00	580,623,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	573,050,500.00	580,623,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	437,965,108.00	164,798,860.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,382,000.00	4,128,960.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	407,054,108.00	160,669,900.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	16,529,000.00	00.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	886,327,760.00	761,628,360.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	886,327,760.00	761,628,360.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	675,306,609.93	555,665,817.91
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	383,560,536.79	397,769,963.09
210101	Үндсэн цалин	264,831,467.98	274,406,063.09
210102	Нэмэгдэл	83,355,100.00	103,695,900.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	35,373,968.81	19,668,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	45,668,794.33	52,327,853.95
210201	Тэтгэврийн даатгал	32,579,591.24	38,141,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,051,923.83	3,407,462.91
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,136,649.71	3,147,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	627,329.92	634,643.02
210205	Эрүүл мэндийн даатгал	6,273,299.63	6,996,548.02
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,166,233.83	4,680,498.94
210301	Гэрэл, цахилгаан	1,836,027.50	2,858,900.00
210302	Түлш, халаалт	2,340,206.33	1,425,598.94
210303	Цэвэр, бохир ус	990,000.00	396,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	31,060,300.00	24,977,382.93
210401	Бичиг хэрэг	2,869,500.00	807,300.00
210402	Тээвэр, шатахуун	23,140,700.00	22,268,960.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,452,100.00	1,386,422.93
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,598,000.00	514,700.00
2105	Нормативт зардал	6,150,000.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,150,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	196,000.00	00.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	196,000.00	00.00
2107	Томилолт, зочны зардал	3,520,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	3,520,000.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	199,984,744.98	75,910,119.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	196,524,366.98	68,444,715.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,485,000.00	6,115,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	433,328.00	400,950.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,107,250.00	949,454.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	184,800.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	250,000.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	211,021,150.07	205,962,542.09
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,471,420.00	18,735,600.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	16,471,420.00	18,735,600.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	194,549,730.07	187,226,942.09
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	194,549,730.07	187,226,942.09
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	145,668,108.00	00.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	145,668,108.00	00.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	145,668,108.00	00.00
2200	Дотоод эх үүсвэрээр	145,668,108.00	00.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	145,668,108.00	00.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(145,668,108.00)	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	600,623,000.00	570,032,457.91	30,590,542.09	94.9
УРСГАЛ ЗАРДАЛ	600,623,000.00	570,032,457.91	30,590,542.09	94.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	555,861,200.00	551,296,857.91	4,564,342.09	99.2
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	398,146,900.00	397,109,963.09	1,036,936.91	99.7
Үндсэн цалин	275,443,000.00	274,406,063.09	1,036,936.91	99.6
Нэмэгдэл	103,695,900.00	103,695,900.00	0.00	100.0
Унаа хоолны хөнгөлөлт	19,008,000.00	19,008,000.00	0.00	100.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	54,079,500.00	52,327,853.95	1,751,646.05	96.8
Тэтгэврийн даатгал	38,341,600.00	38,141,600.00	200,000.00	99.5
Тэтгэмжийн даатгал	3,934,500.00	3,407,462.91	527,037.09	86.6
ҮОМШӨ-ний даатгал	3,147,600.00	3,147,600.00	0.00	100.0
Ажилгүйдлийн даатгал	786,900.00	634,643.02	152,256.98	80.7
Эрүүл мэндийн даатгал	7,868,900.00	6,996,548.02	872,351.98	88.9
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,905,400.00	4,680,498.94	224,901.06	95.4
Гэрэл, цахилгаан	2,858,900.00	2,858,900.00	0.00	100.0
Түлш, халаалт	1,568,500.00	1,425,598.94	142,901.06	90.9
Цэвэр, бохир ус	478,000.00	396,000.00	82,000.00	82.8
Хангамж, бараа материалын зардал	21,609,200.00	21,508,422.93	100,777.07	99.5
Бичиг хэрэг	808,700.00	807,300.00	1,400.00	99.8
Тээвэр, шатахуун	18,898,500.00	18,800,000.00	98,500.00	99.5
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,387,300.00	1,386,422.93	877.07	99.9
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	514,700.00	514,700.00	0.00	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	77,120,200.00	75,670,119.00	1,450,081.00	98.1
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	68,958,200.00	68,204,715.00	753,485.00	98.9
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	6,115,000.00	6,115,000.00	0.00	100.0
Даатгалын үйлчилгээ	494,000.00	400,950.00	93,050.00	81.2
Тээврийн хэрэгслийн татвар	1,117,900.00	949,454.00	168,446.00	84.9
Тээврийн хэрэгслийн оношлогоо	185,100.00	00.00	185,100.00	0.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	250,000.00	00.00	250,000.00	0.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	44,761,800.00	18,735,600.00	26,026,200.00	41.9
Бусад урсгал шилжүүлэг	44,761,800.00	18,735,600.00	26,026,200.00	41.9
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	44,761,800.00	18,735,600.00	26,026,200.00	41.9
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	600,623,000.00	596,829,500.00	3,793,500.00	99.4
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	580,623,000.00	580,623,000.00	0.00	100.0
Улсын төсвөөс санхүүжих	580,623,000.00	580,623,000.00	0.00	100.0
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	20,000,000.00	16,206,500.00	3,793,500.00	81.0
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20,000,000.00	16,206,500.00	3,793,500.00	81.0
АЖИЛЛАГСАДЫН ТОО	41	41		
Удирдах ажилтан	1	1		
Гүйцэтгэх ажилтан	26	26		
Үйлчлэх ажилтан	8	8		

Гэрээт ажилтан	6	6	
----------------	---	---	--

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	4,368,960.00
УРСГАЛ ЗАРДАЛ	-	4,368,960.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	4,368,960.00
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	660,000.00
Унаа хоолны хөнгөлөлт	-	660,000.00
Хангамж, бараа материалын зардал	-	3,468,960.00
Бичиг хэрэг	-	00.00
Тээвэр, шатахуун	-	3,468,960.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	240,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	240,000.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	160,429,900.00
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	-	160,429,900.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	164,798,860.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	-	164,798,860.00
ЗГНХ,ЗДНХерөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	4,128,960.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	160,669,900.00
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгадагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгадагч байгууллагад аж ахуй нэгж болон иргэнээс хандив авахгүй байх, анхан шатны баримт бүрдүүлэлтийг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 1 дүгээр сарын 25-аас 2022 оны 2 дугаар сарын 23-ны хооронд Нью Эстимэйтор Аудит ХХК-ийн ахлах аудитор Ж.Үхэртар, аудитор Б.Алтанцэцэг нар гүйцэтгэж, хяналтыг захирал Т.Бүжидмаа хэрэгжүүлсэн.

Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 24-ны өдрийн 78 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны эрхэм зорилго нь Богдхан уулын дархан цаазат газрын экологийн тэнцвэрт байдлыг хадгалан байгалийн нөөц баялгийн хамгаалалт, ашиглалтын менежментийг зөв зохистой явуулах, Монгол Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн болон Байгаль орчны багц хуулиудын хэрэгжилтийг хангахад оршино.

Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Богдхан уулын байгалийн унаган төрх, ургамал амьтны аймгийг хамгаалах, өсгөн үржүүлэх, ан амьтныг нутагшуулах үйл ажиллагаа явуулна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаал “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”
- Нийгмийн даатгалын тухай хууль

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Байгаль орчин, аялал, жуулчлалын яамны хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас тайлант оны ажлын төлөвлөгөө, гүйцэтгэлд аудит хийгээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлан, суурь үзүүлэлтийг нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн нийт зардал 813,999.2 мянган төгрөгөөс 2.0 хувиар буюу 16,279.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 13,023.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 25,130.2 мянган төгрөгөөр буюу 2.3 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, үндсэн хөрөнгө, засгийн газрын хувь оролцоо данснууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

			/мянган төгрөг/
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	160,669.9	650.1	(160,019.8)
Бараа материал	120,682.9	109,023.1	(11,659.8)
Үндсэн хөрөнгө	804,168.1	950,717.5	146,549.4
Нийт хөрөнгө	1,085,520.9	1,060.390.7	(25,130.2)
Засгийн газрын хувь оролцоо	1,085,520.9	1,060.390.7	(25,130.2)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,085,520.9	1,060.390.7	(25,130.2)

Дансны үлдэгдэл гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Авлага данс үлдэгдэл 650.1 мянган төгрөг болж байгаа нь НДШ төлөлтийг илүү тооцоолон төлснөөс үүссэн авлага байна.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 950,717.5 мянган төгрөг болж 146,549.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд үнэ төлбөргүй шилжиж ирсэн хөрөнгө, гадны байгууллагын тусламжаар ирсэн хөрөнгөөс шалтгаалжээ. Энэ нь БОАЖС-ын 2021 оны 9 дүгээр сарын 20-ний өдрийн А/283 тоот тушаалаар 42,640.0 мянган төгрөг, БОАЖЯ-ны агаарын бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрөөс 22,863.6 мянган төгрөг, Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” төслийн хүрээнд 155,331.6 мянган төгрөг, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын А-1/1690 тоотой Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ) төслөөс 47,518.1 мянган төгрөг, бусад хандиваар 19,449.1 мянган төгрөгийн хөрөнгө хүлээн авсан байна.
- Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,060,390.7 мянган төгрөг болж 25,130.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 246,682.2 мянган төгрөгөөр буюу 21.7 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс тайлант жил хуваарилах хөрөнгө байгаагүйгээс шалтгаалжээ.

Нийт зардал өмнөх оноос 103,941.9 мянган төгрөгөөр буюу 12.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бусдаар гүйцэтгэсэн ажил үйлчилгээ, элэгдлийн зардал, төвлөрүүлэх шилжүүлэг байна. Бусдаар гүйцэтгүүлсэн бараа үйлчилгээний зардал буурсан нь тайлант онд нэмэлт санхүүжилттэй холбоотой зардал гараагүй байна. Төвлөрүүлэх орлого нь бурхан багшийн цэцэрлэгт хүрээлэнгийн хэвийн үйл ажиллагааг хангах, сэргээн засварлах ажилд шаардлагатай хөрөнгийн үлдэгдэл болох 160,429.9 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлснээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 922,438.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 316,838.7 мянган төгрөгөөр бууруулж 605,599.5 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 605,599.5 мянган төгрөгийн төсөв баталснаас 585,599.5 мянган төгрөгийг улсын төсвөөс 20,000.00 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ. Баталсан төсвөөс Засгийн газрын 43 дугаар тогтоолын хүрээнд 4,976.5 мянган төгрөгөөр бууруулж санхүүжүүлсэн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 580,623.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 16,206.5 мянган төгрөг, нийт 596,829.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 570,032.5 мянган төгрөгийг зарцуулж 26,797.0 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 570,032.4 мянган төгрөг буюу 94.9 хувьтай байна.

Хүснэгт-2 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл					/мянган төгрөг/	
	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	486,903.0	486,885.60	(17.40)	99.9
1.2	80219	Харуул хамгаалалтын зардал	88.2	88.00	(0.20)	99.7
1.3	80221	Гэрээгээр ажиллагсдын зардал	40,585.80	40,585.80	-	100.0
1.4	80802	Тэтгэвэрт гарахад олгох 1 удаагийн буцалтгүй тэтгэмж	44,761.80	18,735.60	(26,026.20)	41.8
1.5	81701	Байгаль хамгаалах зардал	18,442.50	18,223.50	(219.00)	98.8
1.6	81703	Ургамал хамгаалах зардал	9,841.70	9,307.30	(534.40)	94.6

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нийслэлийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 4,128.9 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас өмнөх тайлант оны 160,669.9 мянган төгрөгийн авлага хүлээн авч, нийт 164,798.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс 4,368.9 мянган төгрөгийг гал түймрээс урьдчилан сэргийлэхэд зарцуулж, 160,429.9 мянган төгрөгийн буцаан төвлөрүүлсэн.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны эрхэм зорилгын хүрээнд тайлант онд 7 зорилт дэвшүүлэн түүний хүрээнд 47 арга хэмжээ зохион байгуулж 44 арга хэмжээний биелэлт 100 хувь 4 арга хэмжээний биелэлт 80 хувь гэж дүгнэсэн байна. Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 6 хөтөлбөр 1 арга хэмжээний хэрэгжилт 100 хувь, хөтөлбөр, арга хэмжээнд төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 94.9 хувийн биелэлттэй байна.

3.8 Аудитын гол асуудал

Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны 2021 оны санхүүгийн тайлангийн аудитад нөлөөлөх гол асуудал байхгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа нь тайлант онд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйл 4.1.3-т “тогтоосон хугацаанд тогтмол шуурхай оруулж байх” заалттай нийцсэн, мөнгө түүнтэй холбогдох тушаал шийдвэрийн хуулбар бүрэн байршуулсан байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Богдхан уулын дархан цаазат газар нь тайлант онд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна. Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны тайлант онд батлагдсан төсөв нь 605,599.5 мянган төгрөг, гүйцэтгэлээр 570,032.4 мянган төгрөг зарцуулсан байна.

Энэ нь Монгол улсын Засгийн газрын “төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43-р тогтоолын 1.1 “Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэсэн” заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 үндэслэн шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх, албан шаардлага өгөх

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар илэрсэн 5,000.0 мянган төгрөгийн алдааг залруулж, өгсөн зөвлөмжийг жилийн эцсийн аудитаар дахин хянахад хэрэгжсэн байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн шилэн данстай холбоотой 1 албан шаардлага, 4,860.2 мянган төгрөгийн 1 зөвлөмжийг хэрэгжүүлж, 58 толгой адуу дутагдсан асуудлыг эцэслэн шийдэж, байгууллагыг хохиролгүй болгох зөвлөмж биелээгүй байна.

Хүснэгт-3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	239,468.7	1	239,468.7	1	239,468.7	100.0
Зөвлөмж	2	48,360.4	1	4,860.2	1	43,500.0	10.1
Нийт дүн	3	287,829.1	2	224,484.9	1	43,500.0	50.9

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаанд дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 91,361.2 мянган төгрөгийн 7 алдаа зөрчил илэрснээс, 68,758.7 мянган төгрөгийн 3 алдааг залруулж, өмнөх оны хэрэгжээгүй зөвлөмжтэй холбоотой зөрчилд 1 албан шаардлага, 22,602.5 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Адуун сүргийн нас дэвшилтийг үр дүнгийн тайланд 21,550.0 мянган төгрөгөөр зардлаар илэрхийлсэн;
- Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг 11,410.7 мянган төгрөгөөр дутуу илэрхийлж, санхүүгийн үр дүнгийн тайланд тайлагнасан;
- Унаа хоолны хөнгөлөлт болон тээвэр шатахууны 35,798.0 мянган төгрөгийн зардлыг буруу ангилалд бүртгэсэн.

Залруулагдаагүй алдаа, зөрчлийн дүн 22,602.5 төгрөг нь тогтоосон ерөнхий материаллаг байдал 16,279.9 мянган төгрөгөөс хэтэрсэн тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

4.2 Албан шаардлага

1. Бараа материалын дансны биологийн хөрөнгөнд бүртгэлтэй 2020 онд дутагдсан 58 толгой адуун сүргийн асуудлыг эцэслэн шийдвэрлэж байгууллагыг хохиролгүй болгох гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй.

Энэ нь УСНББОУС 12 бараа материалын стандарт 38-д “бараа материал гэмтсэн, эсвэл хэсэгчлэн хорогдсон бол өндөр дүнгээр тусгаж болохгүй” гэж заасантай нийцэхгүй, оршин байх ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Адуун сүргийн дутагдлыг шийдвэрлэх албан шаардлага өгөх.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. *Худалдан авалттай холбоотой асуудал*

Илрүүлэлт:

Тайлант онд 6 аж ахуй нэгжээс 3,153.4 мянган төгрөгийн худалдан авалтын НӨАТ-ын төлбөрийн цахим баримт гаргуулан аваагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4 “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 5-д “төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм” гэсэн заалттай нийцээгүй тохиолдсон байх ба эрх үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлж, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах

2. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант онд аж ахуй нэгж, байгууллага болон иргэнээс 19,449.1 мянган төгрөгийн автомашин болон тавилга эд хогшил авч үндсэн хөрөнгөнд бүртгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2 "хуульд өөрөөр заагаагүй бол зөвхөн доор дурдсан нийгмийн үйлчилгээ үзүүлдэг төсвийн байгууллага энэ хуульд заасан журмын дагуу хандив тусламж авч болно" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллах, цаашид иргэн аж ахуй нэгж байгууллагаас хандив тусламж авахгүй, зөрчлийг давтан гаргахгүй байх

3. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн балансад тэг үлдэгдэлтэй үндсэн хөрөнгө байна.

Энэ нь ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолын 7.1 "төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Анхны өртгөө бүрэн нөхсөн ашиглалтгүй болсон үндсэн хөрөнгийг данснаас хасах, цаашид ашиглах боломжтой үндсэн хөрөнгийн дахин үнэлүүлэх талаар холбогдох байгууллагаас зөвшөөрөл авах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/ д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	дүн	тоо	дүн	Тоо	дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар																
1	БХДЦГХЗ	АХГ-2022/12/НА-СТА-ТШЗ	Биологийн хөрөнгийн нас дэвшлийг буруу бүртгэсэн	СҮДТ-ийн тайланд залруулга хийсэн	1	21,550.0	1	21,550.0								
2	БХДЦГХЗ	АХГ-2022/12/НА-СТА-ТШЗ	Шатахуун зардлыг түлш халаалтын зардалд ангилж бүртгэсэн, унаа хоолны хөнгөлөлтийг үндсэн цалингийн зардалд ангилж бүртгэсэн	СҮДТ-ийн тайланд ангилал залруулсан	1	35,798.0	1	35,798.0								
3	БХДЦГХЗ	АХГ-2022/12/НА-СТА-ТШЗ	Тоног төхөөрөмжийн элэгдэл тооцоолоогүй мөн элэгдүүлэх жилийн буруу бүртгэснээс элэгдлийн зөрүү үүссэн	СҮДТ-ийн тайланд ангилал залруулсан	1	11,410.7	1	11,410.7								
4	БХДЦГХЗ	АХГ-2022/12/НА-СТА-ТШЗ	АН болон иргэнээс хандиваар авсан тавилга, автомашин байна	Төсвийн тухай хуулийн хэрэгжилтэд анхаарч, цаашид иргэн аж ахуй нэгж байгууллагаас хандив тусламж авахгүй, зөрчлийг давтан гаргахгүй байх	1	19,449.1									1	19,449.1
5	БХДЦГХЗ	АХГ-2022/12/НА-СТА-ТШЗ	Зарим худалдан авсан ажил гүйлгээг дахин давтагдашгүй төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй байна	Төлбөрийн цахим баримтыг бэлтгэн нийлүүлэгчээс бүрэн гаргуулах, татварын цахим системээр худалдан авалтыг тухай бүрэн хянаж ажиллах	1	3,153.8									1	3,153.8
6	БХДЦГХЗ	АХГ-2022/12/НА-СТА-ТШЗ	Өмнөх аудитаар өгсөн дутагдсан 58 толгойны адуун сүргийн асуудлыг тайлант онд эцэслэн шийдэх зөвлөмж хэрэгжээгүй	Төсөвт зардлыг хэмнэх, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах, төрөөс гаргасан тогтоол шийдвэрийг хэрэгжүүлж ажиллах	1	-					1	-				

7	БХДЦГХЗ	АХГ-2022/12/НА-СТА-ТШЗ	Үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгө байна.	Тус үндсэн хөрөнгүүдийг данснаас хасах, цаашид ашиглах боломжтой үндсэн хөрөнгийн дахин үнэлүүлэх талаар холбогдох байгууллагаас зөвшөөрөл авах	1	-									1	-
Нийт дүн					7	91,361.2	3	68,758.7			1	-			3	22,602.9
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал																
8	БХДЦГХЗ	АХГ-2022/12/НА-СТА-ТШЗ	Засгийн газрын 43-р тогтоолыг хэрэгжүүлж ажиллаагүй, төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаагүй	Төсөвт зардлыг хэмнэх, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах, төрөөс гаргасан тогтоол шийдвэрийг хэрэгжүүлж ажиллах	1						1	-				
Дүн					1						1					
Нийт дүн					8	91,361.2	3	68,758.7			2	-			3	22,602.9



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 145/АД 150054

Улаанбаатар хот

АХГ-2022/12/НА-СГА-ОУС

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу хийсэн Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд баталсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гарган ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1 "Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д заасныг үндэслэн

ШААРДАХ нь:

1. Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөн зарцуулах, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл арга хэмжээг тэвчиж, үргүй зардал гаргахгүй байхад анхаарч, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Богдхан уулын ДЦГ-ын хамгаалалтын захиргааны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Пүрэвжав, нягтлан бодогч С.Одончимэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
НЬЮ ЭСТИМЭЙТОР АУДИТ ХХК-ийн
АУДИТОР

Ц НАРАНЧИМЭГ
Т.ГҮНЖИДМАА

ЖҮХЭРТАР

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

9019120396
10.10.2020 Bichig_Kherev\Alban_Shaardlaga\2022\0225 Auditin 2 Газар-204.Docx

0010800656



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25

№ 194/А0150059

Улаанбаатар хот

АХГ-2022/112/НА-СТА-ПМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу хийсэн Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж хэрэгжүүлээгүй, бараа материал дансанд бүртгэлтэй 43,500,000.00 төгрөгийн дансны үнэтэй 58 толгой дутагдсан адуун сүргийн асуудлыг эцэслэн шийдээгүй байна.

Энэ нь УСНББОУС 12 бараа материалын стандарт 38-д "Бараа материал гэмтсэн, эсвэл хэсэгчлэн хорогдсон бол өндөр дүнгээр тусгаж болохгүй" гэж заасантай нийцэхгүй, оршин байх ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Богдхан уулын ДЦГ-ын хамгаалалтын захиргааны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Гүрэвжав, нягтлан бодогч С.Одончимэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
НЬЮ ЭСТИМЭЙТОР АУДИТ ХХК-ИЙН
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Г.ГҮНЖИДМАА

Ж.ҮХЭРТАР

9006109
9019120396

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Kherig\Alban_Shaardlaga\2022\0225 Auditin 2 Gazar-205.Docx

0010800060

[illegible]